

СУВИЛГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Г.ШҮРЭНМЯГМАР

СУ-ны магистр, ахлах багш

Лекцийн 1-р хэсэг



Сувилахуйн үйл ажиллагааны онолын үндэслэл

Сувилахуйн үйл ажиллагааны 5 шатлал

Сувилахуйн үйл
ажиллагааны 5
шатлалын онолыг
үндэслэгч нь Иреланд
гаралтай Америк иргэн
А.Ж Орландо юм.
Энэхүү онол нь 1958
оноос хэрэгжиж эхэлсэн
түүхтэй.



А.Ж Орландогийн онол

Түүний онолоор ихэнх үйлчлүүлэгчид өвдсөн үедээ амаар болон бие сэтгэлээрээ “туслаач” гэж хашхирч байдаг тул сувилагч үйлчлүүлэгчийн тухайн үеийн **сэтгэл зүй, зан төлөв, хэрэгцээг** нь тодорхойлж илэрхийлж гаргах хэрэгтэй.

Энэхүү үйл ажиллагаа нь 5 үе шаттай бөгөөд эдгээр нь **үнэлгээ, онош, төлөвлөлт, гүйцэтгэл, дүгнэлт** зэрэг болно гэж үзсэн.

Сувилахуйн үйл ажиллагаа


- Сувилахуй (Nursing) гэдэг нь үйлчлүүлэгчийн бие бялдар, сэтгэц, нийгмийн эрүүл мэндийн байдлыг шүүмжлэлт сэтгэлгээгээр дамжуулан дүн шинжилгээ хийж, асуудлыг тодорхойлсны үндсэн дээр шинжлэх ухаанд суурилсан сувилахуйн төлөвлөгөө гаргаж, тус үйлчилгээ үзүүлэн үйлчлүүлэгчийн эрүүл мэндийг сахин хамгаалах юм.

Сувилгааны үйл ажиллагаа гэж юу вэ?

- Сувилгааны үйл ажиллагаа нь хүн нэг бүрт сувилахуйн тусламжийг чанарын өндөр түвшинд үзүүлэх, дэс дараалалтай, тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагаа юм.

Сувилгааны үйл ажиллагаа нь:

1. Үнэлэх
2. Оношлох
3. Төлөвлөх
4. Хэрэгжүүлэх
5. Дүгнэх гэсэн 5 үе шаттай.



Сувилгааны үйл ажиллагаа гэж юу вэ?

- Сувилахуйн үйл ажиллагаа (Nursing process) бол сувилагч үйлчлүүлэгчид сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ гаргаж буй шүүмжлэлт сэтгэлгээний үйл явц юм.



Сувилахуйн үйл ажиллагааны онцлог

- Сувилахуйн үйл ажиллагаа нь сувилагч үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдлыг шалгаж, түүний эрүүл мэндийн хэрэгцээг хангах цар хүрээг тогтоон, үр дүнтэй, тусгайлсан сувилахуйн тусламж үйлчилгээ хэрэгжүүлэх аргыг гарган харуулдаг. Сувилахуйн үйл ажиллагаа нь дараах онцлогуудтай.

Сувилахуйн үйл ажиллагааны онцлог

Системтэй байх: Сувилахуйн үйл ажиллагаа бүр шат дараалсан ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг болдог. Мөн өмнөх үйл ажиллагааны гүйцэтгэл дараагийн шатны ажиллагаанд нөлөөлнө.

Динамик: Сувилахуйн үйл ажиллагааны шатлал бүр нь ээлж дараатай байх тул шатлал бүр нь дараагийнхаа шатлалд нөлөөлдөг. Энэхүү таван шатлалын хооронд харилцан үйлчлэх, давхцах, тохиолдол гарна.

Сувилахуйн үйл ажиллагааны онцлог

Үйлчлүүлэгч төвтэй: Сувилагч сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ зөвхөн ур чадварт төвлөрөх бус тухайн тусламж үйлчилгээ нь үйлчлүүлэгчийн зорилгыг биелүүлэхэд тус болж байгаа эсэх, яаж туслах боломжтой эсэхэд анхаарлаа хандуулах ёстой.

Сувилахуйн үйл ажиллагааны онцлог

Үр дүн (зорилго) төвтэй: Сувилагч үйлчлүүлэгчийн эрүүл мэндийг дэмжих, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг сэргээхийн тулд зорилго, хүлээгдэх үр дүнг тодорхойлно. Улмаар уг зорилго, үр дүнд хүрэхийн тулд сувилахуйн зохих тусламж үйлчилгээг сонгон хэрэгжүүлнэ.

Сувилахуйн үйл ажиллагааны онцлог

Нийтлэг байдлаар хэрэгжүүлэх боломж:

Үйлчлүүлэгчийн өвчний байдал, наснаас үл хамааран эмнэлэг, тасаг, өрхийн сувилахуй, сургууль, үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн талбай гэх мэт бүхий л орчинд хэрэгжүүлэх боломжтой.

Танин мэдэхүйн сэтгэлгээнд тулгуурлах:

Сувилахуйн үйл ажиллагааны цар хүрээг мөрдөж ажилласан ч үр дүнд хүрэхгүй тохиолдол гарч болно. Тиймээс сувилахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргахын тулд шүүмжлэлтэйгээр сэтгэх явцдаа танин мэдэхүйн ур чадвараа ашиглах хэрэгтэй.

Лекцийн 2-р хэсэг

**Сувилгааны 5 шатлал
ГЭЖ ЮУ ВЭ?**

**1-р шат буюу үнэлэх
шат гэж юу вэ?**

ҮНЭЛЭХ

1. Сувилагч үйлчүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх гэдэг нь үйлчлүүлэгчийн өвчин, шаналгаа, зовиурыг илрүүлэх зорилгоор **АЖИГЛАХ, АСУУХ, БОДИТ ҮЗЛЭГ** хийж мэдээлэл цуглуулах, цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх, мэдээллийг тэмдэглэх, сэтгэн бодох, шийдвэр гаргах ур чадварт суурилсан үйл ажиллагаа юм.

**2-р шат буюу оношлох
шат гэж юу вэ?**

Оношлох

- **Сувилахуйн онош гэдэг нь үйлчүүлэгчийн биеийн байдлыг үнэлсний дүнд дүгнэлт хийж шийдвэр гаргах буюу сувилагчийн үнэлгээнд үндэслэн үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдлын одоогийн болон цаашид үүсч болзошгүй асуудлыг илрүүлэн гаргах шинж тэмдгийн, эмнэлзүйн дүгнэлт болно.**
- **Сувилахуйн онош бол үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн бодит болон далд нөхцөл байдал, хэрэгцээ, түүний хариу үйлдэлд тулгуурлан гаргах сувилагчийн эмнэлзүйн дүгнэлт (clinical judgment) юм.**

**3-р шат буюу төлөвлөх
шат гэж юу вэ?**

ТӨЛӨВЛӨХ

Сувилахуйн төлөвлөгөө нь сувилахуйн оношийн дагуу асуудлыг шийдвэрлэхийн тулд үзүүлэх асаргаа, сувилгааг

- Хэрхэн
- Ямар хугацаанд
- Ямар давтамжтайгаар хийж хэрэгжүүлэх
- Шийдвэрлэх арга зам, гарцыг үйлчлүүлэгчтэй зөвшилцсөний үндсэн дээр үнэн бодитой байдлаар тодорхойлон бичсэн тэмдэглэл болно.

Төлөвлөх

Сувилахуйн төлөвлөгөөг үйлчлүүлэгчийн эрүүл мэндэд тулгарсан асуудал, зовиур шаналгааг хамтран шийдвэрлэх гол зарчмыг баримтлан нэн яаралтай, чухлаас нь эхлэн ач холбогдлоор нь дугаарлан төлөвлөнө.

**4-р шат буюу хэрэгжүүлэх
шат гэж юу вэ?**

Хэрэгжүүлэх

- Сувилахуйн хэрэгжүүлэх үе шат нь төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр сувилагчийн гүйцэтгэсэн ажилбар, үйл ажиллагааны биелэлт болно.
- Төлөвлөгөөг өөрчлөх шаардлагатай, дахин үнэлгээ явуулж, төлөвлөх шаардлагатай бол тухай бүрт бичиж тэмдэглэсний үндсэн дээр төлөвлөлтийг сайжруулан, шинээр төлөвлөж байна.

**5-р шат буюу дүгнэх
шат гэж юу вэ?**

Дүгнэх

- Энэхүү үе шат нь тавьсан зорилт, төлөвлөлт хэрхэн биелж, үйлчлүүлэгчийн биед ямар ахиц гарсан, дахин төлөвлөх шаардлагатай эсэх талаар хийсэн сувилагчийн шийдвэр гаргаж, дүгнэлт хийснийг бичиж тэмдэглэсэн баримт бичиг болно.
- Тавдугаар шатлалын зорилго нь сувилагчийн хийсэн сувилахуйн тусламж, үйлчилгээ нь үйлчлүүлэгчид эерэг нөлөө үзүүлсэн эсэх, зөв сувилгаа хийгдсэн эсэхийг үнэлэх зорилготой.

Дүгнэх

- Сувилагч төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллаж байх явцад үйлчүүлэгчийн биед гарсан өөрчлөлт, үзүүлсэн тусламжийн дүнд гарсан эерэг болон сөрөг үр дагавруудыг байнга хянаж, бичиж тэмдэглэнэ.

Лекцийн 3-р хэсэг

**Сувилгааны 5 шатлал
ГЭЖ ЮУ ВЭ?**

Эмч сувилагчийн

ажлын ялгаа



Жишээ: Эмчийн үзлэг

- Үйлчлүүлэгч С-ийн үе мөч хавдаж өвдөлт ихтэй байсан учир эмнэлэгт хэвтэв. Эмч үйлчлүүлэгчид Ревматоидный артрит гэдэг онош тавив. Уг өвчнийг эмчлэхийн тулд үрэвсэл намдаах эмийг курсээр уулгаж эхлэв. /Эмч үе мөчний үрэвслийг эмчлэхэд анхаарлаа хандуулж байв./



Жишээ: Сувилагчийн үзлэг

- Үйлчлүүлэгч С-ийн үе мөч хавдаж өвдсөнөөс болж хоол идэх, өөрийгөө хувцаслахад хүндрэлтэй, сэтгэлээр их унасан бөгөөд түүнчлэн харж ханддаг 2 ач хүүдээ санаа зовж буйг илрүүлэв.



Жишээ:

- Сувилагч үйлчлүүлэгчийн өвдөлтийг намдаахын тулд эмчийн бичсэн эмийг цагаар уулгав. Хоол идэх, хувцаслахад нь туслахаар болов. Түүнчлэн түүний 2 ач хүүг уулзуулахаар гэрийнхэнтэй нь холбоо барив.
- Сувилагч үе мөчний үрэвслээс болж үйлчүүлэгчид бий болсон зовиурыг багасгахаас гадна тухайн хүнд байгаа бусад асуудлыг шийдвэрлэхэд оролцох ёстой.

Эмч, сувилагчийн ажлыг харьцуулсан нь

Сувилгааны үйл ажиллагаа	Эмчилгээний үйл ажиллагаа
Өвчний улмаас тухайн үйлчлүүлэгч болон түүний ар гэрийнхний зүгээс илэрч буй асуудалд анхаарлаа хандуулдаг	Эрхтэн системд илүү анхаарлаа хандуулдаг
Өдөр тутмын амьдралд нь хэрэг болох зүйлд сургахад үйлчлүүлэгч болон ар гэрт зөвлөгөө өгч сургалт явуулдаг	Өвчин болон гэмтэл хэрхэн эдгэрэх талаар зөвлөгөө өгдөг
Өвчин болон гэмтэлийг хэрхэн эмчлэх талаар эмчээс зөвлөгөө авч, эмчийн заавраар эмчилгээ хийж гүйцэтгэдэг	Өдөр тутмын үйл ажиллагааг сайжруулахад ямар асаргаа сувилгаа хийх талаар сувилагчаас эмч зөвлөгөө авдаг

Сувилгааны үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн ач холбогдол

- Ажлыг эмх цэгцтэй болгох
- Хүн нэг бүрт чанартай сувилахуйн тусламжийг хүргэх
- Сэтгэн бодох, шийдвэр гаргах, асуудал тодорхойлох аргад сургах
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх үндэс болох
- Мэргэжил нэгт нөхөдтэйгөө зөв ойлголцох боломж олгох

Буян хураах сэтгэлийн 5 зарчим

- “Баярлалаа” гэсэн талархсан сэтгэл
- “Уучлаарай” гэсэн эргэцүүлэх сэтгэл
- “Таны ачаар” гэсэн даруу сэтгэл
- “Би хийе” гэсэн үйлчлэлийн сэтгэл
- “Тиймээ” гэсэн дуулгавартай сэтгэл
- Бид бүгдээрээ ийм сэтгэлээр өдөр бүр буян хураавал энэ дэлхий үзэсгэлэнтэй дэлхий болох болно.

Helen Gurley Brown

Ашигласан материал

1. Наранчимэг С., “Сувилгааны үйл ажиллагаа” УБ 2004, 2009, 2011 он
2. Ким Жинь Хьи., “Шүүмжлэлт сэтгэлгээ ба сувилахуйн үйл ажиллагаа” 2021 он
3. Дашдаваа Д., “Сувилахуйн онолын үндэс” УБ 2012
4. Сарантуяа О., Оюунцэцэг С., “Төрөлжсөн сувилгаа” УБ 2012
5. Алтанбагана С., “Сувилахуйн тусламж үйлчилгээний гарын авлага” УБ 2016



The End!
Thank you for
your attention!

